



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮР ЧАДВАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ



АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ

Салбар

Хөдөө аж ахуй

Мэргэжлийн нэр:

Ойжуулагч

Улаанбаатар хот

2018 он

Ажил мэргэжлийн лавлах: Ойжуулагч

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулав.

ISBN:

Ажил мэргэжлийн лавлахын баталгаажилт

Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт (YAMAT 08)-ын код:	6210 - 21
Хөтөлбөрийн индекс: Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (ISCED-13):	Ойн аж ахуй 0821-604
Баталсан байгууллага, огноо:	МБСҮЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоол
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Монголын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Үндэсний Ассоциаци 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр
Хянан засварласан хувилбар, огноо	№ 01 оны ... дугаар сарын ны өдөр
Хянан засварлах хугацаа	Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт орох эсвэл шаардлагатай тохиолдол бүрт
Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан аргачлал	ДАКУМ шинжилгээний аргачлал

Энэхүү ажил мэргэжлийн лавлахыг ХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

АГУУЛГА

	Хуудасны дугаар
Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ	5
2. Ажлын байрны товч тодорхойлолт	6
3. Ажлын байрны тухай мэдээлэл	6
3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
3.2 Ажлын байранд тавигдах шаардлага	
3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт	
3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал	
4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл	7
5 Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил	8
5.1 Мэдлэг	
5.2 Ур чадвар	
5.3 Хандлага, төлөвшил	
6. Үүрэг ба ажилбарын жагсаалт	9
7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо	11
8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл	12
9. Ойжуулагч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл	13

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Ойжуулагч” мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтад оролцогч талууд төрийн байгууллага, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, ажил хайгч, оюутан, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан бөгөөд лавлахыг хэн хэрхэн ямар хэрэгцээнд зориулан ашиглаж болохыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэхэд;
- ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулахад;
- политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд;
- ажил хайгч иргэд, суралцагчид нь ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцлийн талаарх мэдээллийг олж авахад ажил мэргэжлийн лавлахыг ашиглаж болно.

Ажил мэргэжлийн лавлах нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно.

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, хийж гүйцэтгэх үүрэг, ажилбарыг салбарын зөвлөх, мэргэжилтэн, томоохон аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан ажил мэргэжлийн дүн шинжилгээний ДАКУМ арга зүйгээр боловсруулсан.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бодитоор нийцэж, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинэ техник технологи, шинэлэг арга зүйд тулгуурлан хөгжих болтугай.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМДШ	Ажил мэргэжлийн дүн шинжилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл
МБССЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ХЭУЧД төсөл	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл

1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ

Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ажлын байранд тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно. Уг лавлагаас дараах хэрэглэгчид шаардлагатай мэдээллийг олж авна. Үүнд:

Хэрэглэгч	Лавлагаас авах мэдээлэл
Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none">• Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний болон салбар, бүс, орон нутгийн түвшинд тодорхойлж боловсруулах;• Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах, ажлын байр, хөдөлмөрийн харилцааг зохицуулах асуудалтай холбогдох мэдээллийг авах;• Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтны ур чадварыг үнэлэх;• Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зорилгоор ашиглах.
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон Политехник коллеж	<ul style="list-style-type: none">• Ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах;• Тухайн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, багшийг сургаж бэлтгэх;• Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх;• Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйлдвэрлэлийн дадлагыг хамтран зохион байгуулах.
Ажил олгогч	<ul style="list-style-type: none">• Ажлын байрны тодорхойлолт, ажилтан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах;• Ажилтныг үнэлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг үнэлэх, цалинг тогтоох;• Ажлын ачаалал, нормыг тогтоох;• Ажилтныг давтан сургах, мэргэшүүлэхтэй холбогдсон сургалтын хэрэгцээг тодорхойлох, захиалгат сургалтыг төлөвлөх;• Сургалтын байгууллагатай хамтран ажиллах;• Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээрх дадлагажуулах сургалтыг зохион байгуулах.
Иргэн ба ажил хайгч	<ul style="list-style-type: none">• Ажлын байрны нөхцөл, тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл авах;• Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбар, ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар мэдээлэл авах;• Мэргэжлийнхээ хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн талаар ойлголт авах;• Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай мэдээлэл авах;• Ажлын байр, аж ахуйн нэгж байгууллагын талаар мэдээлэл авах.

2. Ажлын байрны товч тодорхойлолт

Ойжуулагч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавигдах шаардлагыг баримтлан мод сөөгний үр бэлтгэх, хөрс боловсруулах, тарьц суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, арчилж хамгаалах ажлыг зориулалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, техникийг ашиглан, инженер техникийн ажилтны удирдлага дор болон бие дааж гүйцэтгэнэ.

3. Ажлын байрны тухай мэдээлэл

3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

- Ойжуулагч нь ойжуулалтын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Ойжуулагч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Ойжуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативын дагуу явуулна.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан нөхцөлд ажиллана.
- Ойжуулагч нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана.
- Ойжуулагч нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллах бөгөөд хуулийн дагуу тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоолгох боломжтой.

3.2 Ажлын байранд тавигдах шаардлага

- Ойжуулагч нь мэргэжлийн боловсролтой, 18 нас хүрсэн иргэн байна.

3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт

- Мэргэжлийн үнэмлэхтэй байна. Зарим тохиолдолд чадамжийн гэрчилгээ шаардагдаж болно.

3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал

- **Машин механизм:** Трактор, тээвэрлэгч машин, өргөгч кран, мод ухагч, мото сийрүүлүүр гэх мэт.
- **Тоног төхөөрөмж:** Анжис, сийрүүлүүр, бул, услалтын систем, помп, цахилгаан үүсгүүр, ойжуулагч техник, тарьц ухагч, хүлэмж, түүний дагалдах тоног төхөөрөмж, чиргүүл, тарьц хадгалах зоорь, модны моторт нүх ухагч, үр хатаагч, үр цайруулагч гэх мэт.
- **Багаж хэрэгсэл:** Метр, алхдаг метр, хүрз, зээтүү, жоотуу, хомбон хүрз, хувин, өвөөлжин царил, колесовын царил, тарьц суулгагч, гар чийдэн, багс, шат, рельеф, луужин, мөчрийн хайч, моторт хөрөө, том жижиг секатор, тармуур, гаапуу, малтуур, гар сийрүүлүүр, галын хор, гал унтраах хэрэгсэл, налуу хэмжигч, сүх, үр түүх багаж хэрэгсэл, түрдэг тэрэг, поттипутки, чийг хэмжигч, дулаан хэмжигч, үлээгч аппарат, усны нөөцийн сав, үүргийн хор шүршигч, цавчуур, гар услуур, гэрлэн урхи, модны өндөр хэмжигч, модны диаметр хэмжигч, жилийн цагирагийн өрөм, ил талбайн сүүдрэвч, хэмжигч ац, хэлбэржүүлэгч хөрөө, сапи, вангуу, зөөврийн бинзений сав,

хөрөөний засварын иж бүрдэл, хөшүүрэг, шаантаг, гар лебёдка, үрнээс дээж авагч гэх мэт.

- **Түүхий эд материал:** Төрөл бүрийн модны үр болон тарьц суулгац, төрөл бүрийн хэмжээтэй таар, хор, геребицид, пункацит, төрөл бүрийн бордоо, бортого, будаг, харандаа, тарьц хийдэг уут, үндэс идэвхижүүлэгч бодис, төрөл бүрийн уяа, тор, хиймэл хөрс, үртэс, элс, хайрга, шатах тослох материал, төрөл бүрийн хучлага, нийлэг хальсан уут, үрслүүрийн хайрцаг, банз, модлог мөчрүүд, үр хадгалах шилэн сав гэх мэт.
- **ХАБЭА-н хэрэгсэл:** ХАБЭА-н шаардлагын дагуу анхны тусламжийн иж бүрдэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл

Ажлын байранд дараах хууль, дүрэм журам, стандартыг баримтална. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ
- YAMAT-08 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
- Ажил мэргэжлийн лавлах толь, Улаанбаатар, 2017
- MNS 2429:2009 Мод сөөгний үр. Үрийн дээж авах арга
- MNS 2430:2009 Мод сөөгний үр. 1000 үрийн жинг тодорхойлох арга
- MNS 2431:2009 Мод сөөгний үр. үрийн чийг тодорхойлох арга
- MNS 2432:2009 Мод сөөгний үр. үрийн амьдрах чадварыг тодорхойлох арга
- MNS 2433:2009 Мод сөөгний үр. үрийн цэвэршилтийг тодорхойлох арга
- MNS 2887:2009 Мод сөөгний үр. үрийн соёололтыг тодорхойлох арга
- MNS 5995:2009 Мод сөөгний үр. үрийн чанарын албан баталгааны маягт
- MNS 5994:2009 Мод сөөгний үр. тариалалтын чанар, Техникийн шаардлага
- MNS 6198:2010 Мод үржүүлгийн талбай сонгох арга. Техникийн шаардлага
- MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
- MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
- MNS 6140:2010 Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага
- MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах арга. Ерөнхий шаардлага
- MNS 6252:2011 Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх арга. Ерөнхий шаардлага
- MNS 6253-1:2011 Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх арга. Ерөнхий шаардлага
- MNS 56253-2:2011 Мод, сөөгний үр тарих арга. Ерөнхий шаардлага
- MNS 6253-3:2011 Мод, сөөгний үр тарьсаны дараа арчлах арга. Ерөнхий шаардлага
- MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах арга. Ерөнхий шаардлага
- MNS 6255:2011 Сөөгний суулгац Ерөнхий шаардлага
- MNS 6256:2011 Сөөгөнцрийн суулгац Ерөнхий шаардлага
- MNS 6257:2011 Улиасны суулгац Ерөнхий шаардлага

- MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгац суулгах арга. Ерөнхий шаардлага
- MNS 6258-2:2011 Мод сөөгний суулгац арчлах арга. Ерөнхий шаардлага

5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил

5.1 Мэдлэг

- M 1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журам, стандарт
- M 2. Байгууллагын дотоод дүрэм, журам
- M 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага
- M 4. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт жилд нэг удаа заавал хамрагдана.
- M 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, сургалтад заавал хамрагдсан байх.
- M 6. Хөдөлмөрийн насны иргэн байх.
- M 7. Ачаалал даах чадвартай, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах.
- M 8. Бие даан хөдөлмөр эрхлэх чадвартай.
- M 9. Мэргэжлийн болон жолооны үнэмлэхтэй.

5.2 Ур чадвар

- УЧ 1. Мэргэжлийн өндөр ур чадвар
- УЧ 2. Ойжуулалтын техник хэрэгслийг ажиллуулах
- УЧ 3. Фенологи /ургамлын үзэгдэл зүй/ ажиглалт хийх
- УЧ 4. Мод үржүүлгийн талбайг зохион байгуулах
- УЧ 5. Мод сөөгний үр мөчир бэлтгэх
- УЧ 6. Хөрс боловсруулалт хийх
- УЧ 7. Ойжуулалт хийх, ойг нөхөн сэргээх технологи ажлыг бие даан гүйцэтгэх
- УЧ 8. Мод сөөгний тарьц суулгацыг ургуулах, арчлах, хамгаалах ажлыг хийх

5.3 Хандлага, төлөвшил

- X 1. Тогтвор суурьшилтай, тууштай ажиллах
- X 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах
- X 3. Байгалийг хамгаалах, ойг нөхөн сэргээх сонирхолтой байх.
- X 4. Ажигч гярхай чанар, нөхцөл байдлыг үнэлэх, дүгнэлт гаргах чадавхитай байх.
- X 5. Хариуцлага, шударга, хянуур нямбай, шуурхай ажиллах
- X 6. Хараагаар орон зайг баримжаалах чадвар, хөдөлгөөний эвсэлтэй байх
- X 7. Чийрэг бие бялдар, цаг агаарын янз бүрийн нөхцөл байдалд ажиллах чадвартай байх
- X 8. Орчин нөхцөлд дасан зохицох
- X 9. Бие дааж болон багаар ажиллах чадвартай
- X 10. Бусдыг дагалдуулан зааж сургах
- X 11. Мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ байнга дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байх
- X 12. Шинийг эрэлхийлэгч, бүтээлч
- X 13. Цагийг үр дүнтэй ашиглах
- X 14. Хувийн зохион байгуулалт сайтай байх
- X 15. Харилцааны соёлтой

6. Үүрэг ба ажилбарын жагсаалт

Ойжуулагчийн хийж гүйцэтгэх ажил үүргийг ажилбараар ангилан тодорхойлов. Мэргэжлийн боловсрол, сургалтаар олгох боломжгүй, дадлага ажлыг ажлын байрны бодит орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай ажилбаруудыг (*) тэмдэглэгээтэй үзүүлэв.

Д/д	Үүрэг	Ажилбар
1	Ойжуулалтын техник хэрэгслийг ажилд бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Үр түүх багаж хэрэгслийг бэлтгэх - Үр боргоцой боловсруулалтын тоног төхөөрөмжийг ажиллуулах* - Мөчрийн багаж хэрэгслийг бэлтгэх - Хөрс боловсруулалтын багаж хэрэгслийг бэлтгэх - Хөрс боловсруулалтын техник хэрэгслийг ажиллуулах* - Тарилтын багаж хэрэгслийг бэлтгэх - Усалгааны тоног төхөөрөмжийг бэлтгэх - Усалгааны тоног төхөөрөмжийг ажиллуулах* - Ургамал хамгааллын техник багаж хэрэгслийг ажиллуулах* - Хүлэмжийн байгууламжийг угсрах* - Түймрээс хамгаалах багаж хэрэгслийг бэлтгэх
2	Мод үржүүлгийн талбайг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Мод үржүүлгийн газрын талбайг сонгох* - Мод үржүүлгийн талбайн зохион байгуулалт хийх* - Мод үржүүлгийн газрыг хамгаалах - Мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвасыг байгуулах* - Мод үржүүлгийн газрын байгууламж барих* - Мод үржүүлгийн газрын усалгааны систем байгуулах* - Мод үржүүлгийн газрын засвар үйлчилгээ хийх
3	Мод сөөгний үр бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Үрийн талбайг бэлтгэх* - Модны үр түүх* - Модны үрийг боловсруулах - Модны үрийг ангилах - Модны үрийг хадгалах - Мод сөөгний үрийг эртжүүлэх
4	Мод сөөгний мөчир бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Эх ургамлыг сонгох* - Модожсон мөчир бэлтгэх* - Бэлтгэсэн мөчрийг хадгалах - Мөчрөөс тайраадас бэлтгэх - Бэлтгэсэн тайраадсыг ангилах - Бэлдсэн тайраадсаа түр хадгалах - Ногоон мөчир бэлтгэх
5	Хөрсөнд боловсруулалт хийх	<ul style="list-style-type: none"> - Хөрс боловсруулах талбайг бэлтгэх* - Талбайн хөрсийг хагалах* - Талбайн хөрсийг сийрүүлэх* - Талбайн хөрсийг бордох* - Хагалсан талбайг тэгшлэх* - Хувиарласан талбайг зааглах* - Хүлэмжийн хөрс субстрат бэлтгэх

6	Модны үр мөчир тарих	<ul style="list-style-type: none"> - Үрийг тарилтанд бэлтгэх - Тарилтын талбайг бэлтгэх* - Тарилтын дараах ариутгал хийх - Модны үр тарих* - Тарьсан үрийг хучих* - Модожсон мөчрийн тайраадсыг тарилтанд бэлтгэх - Модожсон мөчрийн тайраадсыг талбайд суулгах* - Ногоон мөчрийг тарилтанд бэлтгэх - Ногоон мөчрийг хүлэмжинд суулгах*
7	Үржүүлгийн талбайд арчилгаа хийх	<ul style="list-style-type: none"> - Талбайд усалгаа хийх* - Үржүүлгийн талбайн хог ургамлыг устгах - Үржүүлгийн талбайн хөрсийг сийрүүлэх* - Мод сөөгний тарьцийг бордох* - Тарьцийг өвчин хортноос хамгаалах* - Тарьцанд сүүдэрлэлт хийх* - Тарьцийг механик гэмтлээс хамгаалах* - Тарьцийг өвөлжилтөнд бэлтгэх*
8	Мод сөөгний суулгацыг бойжуулах	<ul style="list-style-type: none"> - Тарьцийг бойжуулах талбайд шилжүүлж суулгах* - Бойжуулах суулгацыг хэлбэржүүлэх* - Мод сөөгний суулгацыг услах* - Бойжуулалтын талбайд арчилгаа хийх* - Мод сөөгний суулгацыг бордох* - Суулгацыг өвчин хортноос хамгаалах* - Суулгацыг механик гэмтлээс хамгаалах - Тарьц суулгацыг тоолох
9	Ойжуулалтын тарьц суулгац бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Тарьц суулгацыг ухаж бэлтгэх* - Ухсан тарьц суулгацыг ангилах - Бэлтгэсэн тарьц суулгацыг хадгалах - Ойжуулалтын талбайд тарьц суулгацыг тээвэрлэх* - Талбайд тарьц суулгацыг түр хадгалах - Ойжуулалтын тарьц суулгацыг идэвхижүүлэх
10	Ойжуулалтын ажил хийх	<ul style="list-style-type: none"> - Ойжуулалтын талбайг бэлтгэх* - Ойжуулах талбайн хөрс боловсруулах* - Ойжуулах талбайд суулгалт хийх* - Ойжуулсан талбайг арчлах* - Ойжуулсан талбайг хамгаалах* - Байгалийн сэргэн ургалтанд туслах* - Уул уурхайн нөхөн сэргэлтэнд мод сөөг суулгах* - Ойн зурваст мод сөөг суулгах* - Ногоон байгууламжинд мод сөөг суулгах*
11	Ойн санг хамгаалах	<ul style="list-style-type: none"> - Түймрээс хамгаалах зурвас татах* - Ойг хөнөөлт шавьжаас хамгаалах - Ойг модны өвчлөлөөс хамгаалах - Таримал ойд арчилгаа хийх - Ойд гарсан зөрчлийг мэдээлэх - Ойн дагалдах баялгийг зохистой ашиглах - Биологийн олон янз байдлыг хамгаалах

12	Өөрийгөө хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Шинэ техник технологи судлах - Мэргэжлийн ур чадвараа ахиулах - Мэргэшүүлэх сургалтанд хамрагдах - Мэргэжлийн зэрэг дэв ахиулах - Боловсролын түвшинг ахиулах - Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх - Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх - Харилцааны ур чадвараа сайжруулах - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамрагдах - Бизнес санаагаа хөгжүүлэх - Гамшгаас хамгаалах сургалтанд хамрагдах
----	--------------------	--

7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо

Ойжуулагч нь бусад албан тушаалтантай ажиллах уялдаа холбоог дараах байдлаар дүрслэн харуулав.



Тухайн ажилтныг удирдах албан тушаал болон удирдуулан ажиллах ажилтныг босоо тэнхлэгээр харуулж байгаа бөгөөд энэ нь түүний өсч, дэвших боломжийг мөн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, ойжуулагч нь ойн инженер, ойн техникч нарын хяналтан дор ажиллаж, тракторчин, хөрөөчин, оосорлогч, ойн туслах ажилтныг удирдан, хэвтээ тэнхлэгт байрлах ажилтнуудтай хамтран ажиллана.

8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл

Иргэн тухайн мэргэжлээр суралцах эсвэл ажил хайж байгаа тохиолдолд дараах мэдээлэлтэй танилцаж, сонголтоо хийх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын мэдээлэл	Ажил олгогч байгууллагуудын мэдээлэл
<p>Тухайн мэргэжлээр бэлтгэдэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон политехник коллежийн талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://www.asc.mn</p>	<p>Тухайн мэргэжлээр ажилтан хайж байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://hudulmur-halamj.gov.mn/job/list</p>

9. Ойжуулагч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл

Ажил мэргэжлийн лавлахын ДАКУМ шинжилгээг боловсруулахад оролцсон багийн гишүүд:

- | | |
|-------------------|---|
| 1. Б.Ажиндай | Мод үржүүлэгч, хувиараа |
| 2. Д.Сугарсүрэн | “Төгөл” ХХК-ийн захирал, ойн инженер |
| 3. Г.Наранчимэг | “Мөнгөн навч” ХХК-ийн захирал, ойн инженер |
| 4. С.Тунгалаг | “Хонгор говь” ТББ-ын тэргүүн, ерөнхий агрономич |
| 5. Д.Оюунцэцэг | “Ойн хайгуул” ХХК-ийн захирал, ойн инженер |
| 6. Б.Даваасүрэн | “Мөнхийн түвшин уул” ХХК-ийн захирал, ойн инженер |
| 7. Г.Нэмэхжаргал | “Happy forest” ХХК-ийн ойн инженер |
| 8. М.Алтангэрэл | Мод үржүүлэгч, хувиараа |
| 9. Н.Нарансолонго | “Ногоон хэрэм төсөл”-ийн техникч |
| 10. Н.Пүрэвцэцэг | “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын техникч |
| 11. Н.Борхүү | “Хэнтий аймаг дахь МСҮТ”-ийн ойн мэргэжлийн багш |
| 12. В.Чинчулуун | “Хөвсгөл аймаг дахь МСҮТ”-ийн ойн мэргэжлийн багш |
| 13. Б.Эрдэнэтуяа | “Эко монгол Эрдэнэ МСҮТ”-ийн ойн мэргэжлийн багш |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг баталгаажуулсан:

- | | |
|------------------|--|
| 1. Д.Энхжаргал | “НҮБ-ын ХХААБ-ын Ойн төсөл”-ийн үндэсний зөвлөх |
| 2. Д.Бямбадорж | “ШУА-ийн газар зүй геоэкологийн хүрээлэн”-ийн Ой зүйч |
| 3. Д.Чанцалням | ОУУБИС-ийн ойн тэнхимийн эрхлэгч, дэд профессор |
| 4. Б.Цэнгэл | МУИС ойн судлалын багш, дэд профессор |
| 5. Д.Сайнбаяр | “Ойн ирээдүй” ХХК-ийн Ойн инженер |
| 6. Н.Цагаанцоож | “ШУА-ийн газарзүйн геоэкологийн хүрээлэн”-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор |
| 7. Г.Батсайхан | “ШУА-ийн газарзүйн геоэкологийн хүрээлэн”-ийн Эрдэм шинжилгээний ажилтан |
| 8. Б.Хандаа | “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын Ойн инженер, ой судлаач |
| 9. А.Уранчимэг | “Gobi golden seeds” ХХК-ийн захирал, ойн инженер |
| 10. Г.Алтанцэцэг | “Таримал загийн төгөл” ХХК-ийн захирал |
| 11. Х.Отгонбилэг | “Ховор ургамал сан төв” ТББ-ын ерөнхий зөвлөх |
| 12. Ц.Энхтөр | “Равдубаясгалан” ХХК-ийн захирал |
| 13. Д.Баттуяа | “Хар интоор төв”-ийн захирал |
| 14. Ө.Мөнхзаяа | “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын тарилтын инженер |
| 15. Г.Батцэцэг | “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-ын ойн инженер |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг хянасан хөдөө аж ахуйн салбарын экспертүүдийн төлөөлөл:

- | | |
|------------------|--|
| 1. Ц.Баяр | “Ногоон харш” ХХК-ийн захирал |
| 2. С.Далайсайхан | “Каратис Монгол” ТББ-ын агрономич |
| 3. Д.Батцэнгэл | “Сор” ХХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан дарга |
| 4. Ц.Оюунгэрэл | “Сэнжид Оюу” ХХК-ийн агрономич |
| 5. С.Гэрэлмаа | “МАН-н ЭШХ”-ийн мал зүйч |
| 6. М.Мөнхжаргал | “СБД-ийн Мал эмнэлэг”-ийн малын их эмч |

Ажил мэргэжлийн дүн шинжилгээний чиглүүлэгчид:

- | | |
|------------------|---|
| 1. Б.Цэвээнгэрэл | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Увс аймгийн Улаангом Политехник Коллежийн Нийгмийн түншлэл, зуучлал хариуцсан мэргэжилтэн |
| 2. Д.Эрдэнэбат | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, ХХҮЕГ-ийн Мэргэжлийн болон техникийн боловсролын агуулга, арга зүй хариуцсан мэргэжилтэн |
| 3. Б.Алтмаа | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, СЗСҮТ-ийн МСҮТ-ийн захирал |

Ажил мэргэжлийн лавлахын загварыг боловсруулж, хянасан зөвлөхүүд:

- | | |
|----------------|---|
| 1. Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн |
| 2. Ц.Ганчимэг | АХБ-ны ХЭУЧД төслийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3. Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 4. Г.Батчимэг | ЧССҮ-ний Зөвлөх |

10. Ойжуулагч мэргэжлийн үүрэг, ажилбарын зураглал (ДАКУМ шинжилгээ)

ҮҮРЭГ		АЖИЛБАР										
A	Ойжуулалтын техник хэрэгслийг ажилд бэлтгэх	A-1 Үр түүх багаж хэрэгслийг бэлтгэх BCC	A-2 Үр боргоцой боловсруулалтын тоног төхөөрөмжийг ажиллуулах BAC	A-3 Мөчрийн багаж хэрэгслийг бэлтгэх BCB	A-4 Хөрс боловсруулалтын багаж хэрэгслийг бэлтгэх BBB	A-5 Хөрс боловсруулалтын техник хэрэгслийг ажиллуулах BAB	A-6 Тарилтын багаж хэрэгслийг бэлтгэх BCB	A-7 Усалгааны тоног төхөөрөмжийг бэлтгэх AAB	A-8 Усалгааны тоног төхөөрөмжийг ажиллуулах AAA	A-9 Ургамал хамгааллын техник багаж хэрэгслийг ажиллуулах AAB	A-10 Хүлэмжийн байгууламжийг угсрах AAB	A-11 Түймрээс хамгаалах багаж хэрэгслийг бэлтгэх BCC
	B	Мод үржүүлгийн талбайг зохион байгуулах	B-1 Мод үржүүлгийн газрын талбайг сонгох ABC	B-2 Мод үржүүлгийн талбайн зохион байгуулалт хийх ABC	B-3 Мод үржүүлгийн газрыг хамгаалах AAC	B-4 Мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвасыг байгуулах BBC	B-5 Мод үржүүлгийн газрын байгууламж барих AAC	B-6 Мод үржүүлгийн газрын усалгааны систем байгуулах ABC	B-7 Мод үржүүлгийн газрын засвар үйлчилгээ хийх ABB			
C	Мод сөөгний үр бэлтгэх	C-1 Үрийн талбайг бэлтгэх AAB	C-2 Модны үр түүх AAB	C-3 Модны үрийг боловсруулах AAB	C-4 Модны үрийг ангилах ABC	C-5 Модны үрийг хадгалах ABB	C-6 Мод сөөгний үрийг эртжүүлэх BCC					
D	Мод сөөгний мөчир бэлтгэх	D-1 Эх ургамлыг сонгох ABC	D-2 Модожсон мөчир бэлтгэх ABB	D-3 Бэлтгэсэн мөчрийг хадгалах BBB	D-4 Мөчрөөс тайраадас бэлтгэх ABB	D-5 Бэлтгэсэн тайраадсыг ангилах BCB	D-6 Бэлдсэн тайраадсаа түр хадгалах BBB	D-7 Ногоон мөчир бэлтгэх ABB				
E	Хөрсөнд боловсруулалт хийх	E-1 Хөрс боловсруулах талбайг бэлтгэх AAB	E-2 Талбайн хөрсийг хагалах AAB	E-3 Талбайн хөрсийг сийрүүлэх AAB	E-4 Талбайн хөрсийг бордох ABB	E-5 Хагалсан талбайг тэгшлэх BAB	E-6 Хувиарласан талбайг зааглах BBB	E-7 Хүлэмжийн хөрс субстрат бэлтгэх AAB				
F	Модны үр мөчир тарих	F-1 Үрийг тарилтанд бэлтгэх ABB	F-2 Тарилтын талбайг бэлтгэх ABB	F-3 Тарилтын дараах ариутгал хийх AAB	F-4 Модны үр тарих AAB	F-5 Тарьсан үрийг хучих ABB	F-6 Модожсон мөчрийн тайраадсыг тарилтанд бэлтгэх ABB	F-7 Модожсон мөчрийн тайраадсыг талбайд суулгах AAB	F-8 Ногоон мөчрийг тарилтанд бэлтгэх AAB	F-9 Ногоон мөчрийг хүлэмжинд суулгах AAB		
G	Үржүүлгийн талбайд арчилгаа хийх	G-1 Талбайд усалгаа хийх AAA	G-2 Үржүүлгийн талбайн хог ургамлыг устгах AAA	G-3 Үржүүлгийн талбайн хөрсийг сийрүүлэх BBB	G-4 Мод сөөгний тарьцийг бордох ABB	G-5 Тарьцийг өвчин хортноос хамгаалах AAB	G-6 Тарьцанд сүүдэрлэлт хийх ABB	G-7 Тарьцийг механик гэмтлээс хамгаалах AAB	G-8 Тарьцийг өвөлжинтөнд бэлтгэх AAB			
H	Мод сөөгний суулгацыг бойжуулах	H-1 Тарьцийг бойжуулах талбайд шилжүүлж суулгах BBB	H-2 Бойжуулах суулгацыг хэлбэржүүлэх AAB	H-3 Мод сөөгний суулгацыг услах AAA	H-4 Бойжуулалтын талбайд арчилгаа хийх AAA	H-5 Мод сөөгний суулгацыг бордох ABB	H-6 Суулгацыг өвчин хортноос хамгаалах AAB	H-7 Суулгацыг механик гэмтлээс хамгаалах AAB	H-8 Тарьц суулгацыг тоолох BBB			
I	Ойжуулалтын тарьц суулгац бэлтгэх	I-1 Тарьц суулгацыг ухаж бэлтгэх AAB	I-2 Ухсан тарьц суулгацыг ангилах BBB	I-3 Бэлтгэсэн тарьц суулгацыг хадгалах ABB	I-4 Ойжуулалтын талбайд тарьц суулгацыг тээвэрлэх ABB	I-5 Талбайд тарьц суулгацыг түр хадгалах ABB	I-6 Ойжуулалтын тарьц суулгацыг идэвхижүүлэх BBB					
J	Ойжуулалтын ажил хийх	J-1 Ойжуулалтын талбайг бэлтгэх AAB	J-2 Ойжуулах талбайн хөрс боловсруулах AAB	J-3 Ойжуулах талбайд суулгалт хийх AAB	J-4 Ойжуулсан талбайг арчлах AAA	J-5 Ойжуулсан талбайг хамгаалах AAB	J-6 Байгалийн сэргэн ургалтанд туслах BBB	J-7 Уул уурхайн нөхөн сэргээлтэнд мод сөөг суулгах AAB	J-8 Ойн зурваст мод сөөг суулгах AAB	J-9 Ногоон байгууламжид мод сөөг суулгах AAB		
K	Ойн санг хамгаалах	K-1 Түймрээс хамгаалах зурвас татах AAB	K-2 Ойг хөнөөлт шавьжаас хамгаалах AAB	K-3 Ойг модны өвчлөлөөс хамгаалах AAC	K-4 Таримал ойд арчилгаа хийх AAB	K-5 Ойд гарсан зөрчлийг мэдээлэх BCC	K-6 Ойн дагалдах баялгийг зохистой ашиглах CBV	K-7 Биологийн олон янз байдлыг хамгаалах AAB				
L	Өөрийгөө хөгжүүлэх	L-1 Шинэ техник технологи судлах BCC	L-2 Мэргэжлийн ур чадвараа ахиулах ABB	L-3 Мэргэшүүлэх сургалтанд хамрагдах BCC	L-4 Мэргэжлийн зэрэг дэв ахиулах BBC	L-5 Боловсролын түвшинг ахиулах BBC	L-6 Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх BAC	L-7 хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх ABA	L-8 Харилцааны ур чадвараа сайжруулах ACA	L-9 ХАБЭА-н сургалтанд хамрагдах ABA	L-10 Бизнес санаагаа хөгжүүлэх BAC	L-11 Гамшгаас хамгаалах сургалтанд хамрагдах ACC

ТЭМДЭГЛЭЛ: Саарал өнгөтэй хэсэгт ажлын байран дээр ирэхээс өмнө сургалтын байгууллагаар олгох ажилбарыг заасан бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад заавал тусгана. Цагаан толгойн гурван үсгийн дарааллаар чухал, хүнд, давтамжийн үзүүлэлтүүдийн харьцангуй түвшинг илэрхийлдэг. Ингэхдээ эхний үсэг нь чухлын зэргийг (А-маш чухал, В-чухал, С-чухал биш), хоёр дахь үсэг нь ажилбарын хүндрэлийн түвшинг (А-маш хүнд, В-хүнд, С-хүнд биш), гурав дахь үсэг нь ажилбарыг гүйцэтгэх давтамжийг (А-байнга, В-заримдаа, С-ховор) илэрхийлнэ. Жишээлбэл: Ажилбарыг ABC гэж тэмдэглэсэн бол тухайн ажилбар нь маш чухал, хүнд, ховор гүйцэтгэдэг ажилбар гэсэн утгатай.